



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 0/04

Аварга

Эд хөрөнгө данс бүртгэлээс хасч,
эд хөрөнгө данс бүртгэлд бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын эзэмшлийн 30,800,000 (гучин сая найман зуун мянган) төгрөгийн балансын үнэтэй 05-85 ХЭҮ дугаартай TOYOTA HARRIER маркийн автомашиныг данс бүртгэлээс хассугай.

2.Хэнтий аймгийн Баянмөнх сумаас шилжиж ирсэн 73-78 ХЭҮ улсын дугаартай УАЗ Фургон автомашин 34,000,000 (гучин дөрвөн сая) төгрөгийн балансын үнэтэй, 17,000,000 (арван долоон сая) төгрөг хуримтлагдсан элэгдэлтэй , 17,000,000 (арван долоон сая) төгрөгийн үлдэх өртөг бүхий үндсэн хөрөнгийг данс бүртгэлд бүртгэсүгэй.

3.Дээр дурдсан үндсэн хөрөнгийг хууль тогтоомж, журманд нийцүүлэн хасах, бүртгэх ажлыг зохион байгуулахыг Нярав (Л.Баатархүү) Нягтлан бодогч (О.Анхцэцэг) нарт үүрэг болгосугай .

ДАРГА



Д.УРАНГОО